

АВТОТЭЭВРИЙН ХЭРЭГСЛИЙН ДААТГАЛЫН НӨХӨН ТӨЛБӨРИЙН НЭХЭМЖЛЭЛИЙН МАЯГТ НТ-4

Анхааруулга: Та энэхүү маягыг ашиглан Автотээврийн хэрэгслийн даатгалын гэрээний нөхцлөөр нөхөн төлбөр олгогдож болох аливаа хохирлын нэхэмжлэлийг гаргана. Та юуны өмнө даатгалын гэрээ болон баталгаан дээр бичигдсэн нөхцлүүдийг сайтар уншиж судлан, түүн дээрх таны мэдээлэл үнэн зөв эсэхийг шалгаарай.

Нөхөн төлбөрөө түргэн шийдвэрлүүлэхийн тулд Та үйл явдлыг баримтжуулж, нэхэмжлэлийг баталгаажуулах материалуудын эх хувийг нь энэхүү маягтанд хавсаргасан байх шаардлагатай.

Үүнд:

1. нөхөн төлбөр олгохыг хүссэн албан бичиг (албан байгууллага бол);
2. гэрээ, даатгалын баталгаа;
3. учирсан хохирлын тухай тусгай зөвшөөрөл бүхий хохирол үнэлэгчийн гаргасан хохирлын үнэлгээ, дүгнэлт, акт, материал;
4. осол болсныг нотлох холбогдох мэргэжлийн байгууллагын тодорхойлолт (Замын Цагдаа, Цагдаа, Гал унтраах алба, Шүүх, Шүүх эмнэлэг, ОБГ, Цаг Уур, Эмнэлгийн байгууллага г.м);
5. ослын болон хохиролд орсон автотээврийн хэрэгслийн гэрэл болон гар зураг;
6. осол аваарт оролцсон бүх жолоочийн иргэний үнэмлэх, жолооны үнэмлэх;
7. осол аваарт оролцсон бүх автотээврийн хэрэгслийн гэрчилгээ;
8. гэрчийн мэдэгдэл, бусад шаардлагатай баримтууд. үүнд: засварын газрын баримт, сэлбэг хэрэгслийн нэхэмжлэх, төлбөрийн баримт г.м;

Та даатгалын тохиолдол болсон өдрөөс хойш хуанлийн 90 хоногийн дотор эвдрэл, хохирлын талаар эцсийн тайлан, баримт, материалыг бүрэн гүйцэд, хууль зүйн дагуу өөрийн зардлаар бүрдүүлж манай компанид ирүүлээрэй. Нөхөн төлбөрийг хууран мэхлэх замаар авах гэж оролдсон нь илэрвэл даатгалын гэрээ цуцлагдаж, нөхөн төлбөр авах боломж бүрэн алдагдах ба даатгалын хураамж буцааж олгогдохгүй болно.

Таны өгсөн урьдчилсан мэдээлэлтэй холбоотойгоор нэмэлт мэдээлэл шаардан гаргуулах, шинжээчдийг томилон ажиллуулж, дүгнэлт гаргуулах, шаардлагатай гэж үзвэл даатгалын тохиолдолтой холбогдсон тайлан, баримтуудыг бид шалгах эрхтэй. Таны бүрдүүлсэн баримт бичиг нь эргэлзээтэй эсвэл бүрэн бус бол шаардлагатай гэж үзсэн бусад бичиг баримт шаардах болно.

Бидний хүсэлтийн дагуу Та эрсдэлд орсон автотээврийн хэрэгслийг үзүүлэх мөн хохирлын хэргийг гэрчлэх эд мөрийн баримт, баталгаа, нотолгоо бусад холбогдох мэдээллээр хангах үүрэгтэйг анхаарна уу.

Бүрэн, шаардлага хангасан хохирлын нэхэмжлэл, бусад материалыг хүлээн авснаас хойш ажлын **10** хоног хүртэлх хугацаанд нөхөн төлбөрийг шийдвэрлэнэ. Хэрвээ нэхэмжлэлийг шалгах явцад нэмэлт мэдээлэл цуглуулах, мэргэжлийн байгууллагаар шалгуулах шаардлага гарсан тохиолдолд нөхөн төлбөр шийдвэрлэлтийн хугацааг хойшлуулах болно. Хэрвээ нөхөн төлбөр олгохоос татгалзах тохиолдолд хууль зүйн үндэслэлийг тодорхой гарган, Танд бичгээр мэдэгдэнэ.

Хэрвээ Таны автотээврийн хэрэгсэлд хэн нэгэн этгээд хохирол учруулсан бол Даатгалын тухай МУ-ын хуулийн 8.7 дахь заалтын дагуу бид тэрхүү буруутай этгээдээс төлбөр нэхэмжлэх эрхтэй тул Та бидэнд бүхий л талын туслалцаа үзүүлж хамтран ажиллах үүрэгтэй. Та бидний энэхүү эрхийг ямар нэгэн хэлбэрээр хязгаарласан эсвэл багасгасан тохиолдолд Танд олгох нөхөн төлбөрийн дүнг олгохоос татгалзах эсвэл багасгасан хэмжээгээр нь хасахыг анхаарна уу. Танд буруутай этгээдээс барьцаалсан эд зүйл, хохирол барагдуулах баталгаа байгаа бол бидэнд өгөөрэй.

Бүрэн сүйрлийн үед эсвэл эд ангиудыг сэлбэг хэрэгслээр сольж хохирлыг нөхөн төлөх тохиолдолд ослоос үлдсэн хэсгийг бидэнд шилжүүлж өгнө үү.

Та өөрийн нэхэмжлэлтэй холбоотой мэдээллийг 7711 5555 дугаарын утаснаас аваарай.**Даатгуулагчийн нэр:**

Регистрийн дугаар:	Утас:	Хаяг:
--------------------	-------	-------

Жолоочийн овог нэр:

Регистрийн дугаар:	Жолооны үнэмлэхний дугаар:
--------------------	----------------------------

Хаяг:	Утас:
-------	-------

Автотээврийн хэрэгслийн улсын дугаар:	Марк:
--	-------

Арлын дугаар:	Үйлдвэрлэсэн он:
---------------	------------------

Зах зээлийн үнэ:	Монголд орж ирсэн он:
------------------	-----------------------

Даатгалын гэрээ болон даатгалын баталгааны дугаар:

Даатгалын хугацаа:	Эхлэх:	он	сар	өдөр	Дуусах:	он	сар	өдөр
--------------------	--------	----	-----	------	---------	----	-----	------

Таны даатгалын хамгаалалт:	<input type="checkbox"/> ХААН	<input type="checkbox"/> НОЁН	<input type="checkbox"/> ТҮШМЭЛ	<input type="checkbox"/> ТОРГОН ЦЭРЭГ	<input type="checkbox"/> БУСАД
----------------------------	-------------------------------	-------------------------------	---------------------------------	---------------------------------------	--------------------------------

Даатгалын үнэлгээ:	
--------------------	--

Энэхүү нэхэмжлэл нь даатгалын хугацаан дахь анхны тохиолдол хоёр дахь тохиолдол гурав дахь тохиолдол _____

Осол болсон огноо	
Осол болсон байршил	

Та ослын талаар дэлгэрэнгүй тайлбарлана уу.

Осол Таны болгоомжгүй үйлдлээс эсвэл Таниас шалтгаалсан нөхцөл байдлаас үүссэн үү? <input type="checkbox"/> ТИЙМ <input type="checkbox"/> ҮГҮЙ			
Ослын газар манай ШУУРХАЙ АЛБА очсон эсэх? <input type="checkbox"/> ТИЙМ <input type="checkbox"/> ҮГҮЙ	Ослын газар ЗЦГ очсон уу ? <input type="checkbox"/> ТИЙМ <input type="checkbox"/> ҮГҮЙ Хэрвээ ТИЙМ бол ЗЦГ-аас олгосон тодорхойлолт, акт, бусад баримтыг хавсаргана уу ҮГҮЙ бол яагаад гэдгийг тайлбарлана уу	Та мэргэжлийн байгууллагуудад хандсан уу? (Цагдаагийн газар эсвэл Гал унтраах алба эсвэл Онцгой байдлын газар зэрэг) <input type="checkbox"/> ТИЙМ <input type="checkbox"/> ҮГҮЙ ТИЙМ бол холбогдох ажилтан, хаяг зэрэг мэдээлэл өгнө үү	Танд учирсан хохирлыг нотлох гэрч байгаа бол нэр, хаягийг өгнө үү

Авто осолд өөр автотээврийн хэрэгсэл оролцсон бол дараахь мэдээллийг өгнө үү.

Эзэмшигчийн нэр	Улсын дугаар	Марк	Хаяг, утас

Та гэмтэл, хохирлын талаар дэлгэрэнгүй бичнэ үү. (даатгалын хохирол үнэлэгчийн гаргасан үнэлгээ байгаа бол хавсаргана уу)

Гэмтсэн эд, ангиудын жагсаалт:	Хохирлын мөнгөн дүн:

Таны автотээврийн хэрэгсэлд учирсан хохирлын нийт хэмжээ:

Нөхөн төлбөрийг зөвхөн Таны нэр дээрх данс руу шилжүүлэх тул Та дансны дэлгэрэнгүй мэдээллээ үнэн зөв өгнө үү.

Банкны нэр	Данс эзэмшигчийн нэр	Дансны дугаар

эсвэл Картын дугаар:

НЭХЭМЖЛЭЛ ГАРГАГЧИЙН МЭДҮҮЛЭГ:

Би үнэн зөв мэдүүлснээ баталж байна. Би өөрийн нөхөн төлбөрийн нэхэмжлэлийн асуудлыг шийдвэрлүүлэх зорилгоор миний автотээврийн хэрэгслийн хохиролтой холбоотой бүхий л мэдээллээр Соёмбо Даатгал компанийг хангаж байх эрхийг холбогдох байгууллагын удирдлага, ажилтнууд, гэрчид олгож байна.

Гарын үсэг: _____ Огноо: он сар өдөр

Нэхэмжлэл гаргагчийн нэр:

Материал хүлээн авсан огноо:	Хүлээн авсан ажилтан:
------------------------------	-----------------------